



# **MONLOGISTICS HOLDING JSC (MSE: MLG) H1 2024 Earnings Call Transcript**

## **Танилцуулга**

Хөрөнгийн зах зээлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний СММ Коммуникаци ба Адвайзорийс ХХК нь Монложистикс Холдинг ХК-тай хамтран Earnings call-ийг амжилттай зохион байгууллаа.

Earnings call нь хувьцаат компаниудын удирдлага зах зээлийн мэргэжлийн оролцогч болон шинжээчдэд санхүү, үйл ажиллагааны үр дүн болон ирээдүйн төлөвлөгөөг танилцуулж, мэргэжлийн шинжээчдийн асуултад удирдлагын зүгээс хариулт өгч, мэдээллийг зохистойгоор хүргэх зорилготой.

Мэргэжлийн оролцогч, шинжээч нарын хувьд компанийн талаар үнэн зөв мэдээлэлтэй болж, харилцагчдадаа бодит мэдээллээр хангаж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нь түлхэц болох ач холбогдолтой арга хэмжээ билээ.

### **Монложистикс Холдинг ХК талаас:**

Г.Хишигбат - Гүйцэтгэх захирал  
З.Шинэ-Од - Санхүү эрхэлсэн захирал

### **Оролцогч талаас:**

1. Гүүдсек ҮЦК ХХК - Ц.Чанцал
2. Апекс капитал ҮЦК ХХК - М.Тэмүүлэн
3. Таванбогд капитал ҮЦК ХХК - Ц.Золбаяр, Б.Саруул
4. Сод Ассет Менежмент ХОМК - Г.Маралгоо
5. Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК - Э.Түвшинбилэг, М.Жаргалмаа, Ө.Золжаргал
6. Ашид Ассет Менежмент ХОМК - Д.Болортуяа
7. Балансэд грөүт менежмент ХОМК - Б.Аминаа
8. Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК - Б.Баасандорж, Ш.Түвшинбаяр
9. Мандал Ассет Менежмент ХОМК - Б.Энхтуул
10. Эм Ай Си Си ҮЦК ХХК - Б.Мөнхтуул
11. Голомт Капитал ҮЦК ХХК - Г.Эрдэнэбаясгалан
12. Алтан хоромсог ҮЦК ХХК - М.Ариунтуул
13. Бумбат Алтай ҮЦК ХХК - Б.Хулан
14. Synergy Fund Solution - Ү.Гончигболд
15. Ти Ди Би секьюритис ҮЦК ХХК - Г.Сайнбилэг
16. Профанд инвестментс ХХК - Д.Нэргүй
17. Ард Секюритиз ҮЦК ХХК - Н.Цогбадрах

**Б.Намхайдорж (Operator):** Сайн байцгаана уу? Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Capital Markets Mongolia-оос зохион байгуулж буй хагас жилийн Earnings call-д Монложистикс Групп 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг танилцуулна. Earnings call нь яаж явдаг вэ гэхээр эхний 30 минут компанийн удирдлагууд компанийн танилцуулгыг танилцуулна. Үлдсэн 30 минутад мэргэжлийн оролцогчид маань асуултуудаа асуух байгаа.

За ингээд Хишигбат захирлыг урьж байна.

**Г.Хишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** За баярлалаа, бүгдэд нь энэ өглөөний мэндийг хүргэе. Манай ээлжит earnings call-д оролцож байгаа та бүхэнд баярлалаа.

Өнөөдөр бид 2024 оны хагас жилийн тайлангаа хүргэхэд бэлэн болсон байна. Тайлан маань бидний тухай, стратеги, санхүүгийн зорилт, үйл ажиллагаа, тогтвортой хөгжил, засаглал, санхүүгийн тайлан гэсэн үндсэн 6 хэсгээс бүрдэнэ.

Монложистикс групп нь 2005 оноос буюу одоогоос 19 жилийн өмнө яг импортын B2B зах зээл дээр тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа үзүүлж эхэлсэн. Өнөөдөр толгой компани болон 10 охин компанитайгаар 210 орчим хамт олонтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Монложистикс групп нь яг тээвэр ложистикийн салбартаа төвлөрсөн гэхдээ тээвэр ложистикийн салбар дотроо бүх сегмент дээр нь охин компаниар үйл ажиллагаа явуулдаг онцлогтой.

Манайх дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд гэдэг эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Бидний итгэл үнэмшлээр Монголын хамгийн анхны үндэстэн дамнасан ложистикийн салбарын компанийг бий болгох бүрэн боломжтой гэж хардаг. Тэрнийхээ хойноос ч идэвхтэй ажил хэрэг болгоод явж байгаа. Бид нарын алсын хараа бол 2030 онд орчин үеийн дэд бүтэц үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно. Үнэт зүйлийн хувьд өндөр чадвартай мэргэжлийн хамт олон, бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл, хариуцлага сахилга бат, шударга ил тод байдал инновацлаг багийн сэтгэлгээ гэсэн үнэт зүйлтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

## **Группийн бүтэц**

Монложистик холдинг бол манай группийн толгой компанийн үүрэг гүйцэтгэдэг. Холдинг дээр голцуу R&D, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, үүнээс гадна охин компаниудаа зарим корпорет функцүүдийн үйлчилгээнүүдийг өгдөг байгаа. Үүний хүрээнд хүний нөөц, маркетинг санхүү, ложистикийн функц зэргээр дэмжлэг үзүүлж явдаг. Охин компаниудын хувьд ложистикийн салбарын үндсэн 4 сегмент байдаг. Импорт, экспорт, транзит, бусад гэсэн 4 сегментэд бүгдэд нь үйл ажиллагаа явуулж байна.

Импортын хувьд Монложистикс Ворлдвайд, Монложистикс Карго, Монложистикс Экспресс, Төв Азийн Зам гэсэн 4 компани үйл ажиллагаа явуулж байна. Энэ жилийн хувьд

нэг онцлох мэдээлэл гэвэл Төв Азийн Зам компанийн 51%-ийг Монложистикс групп өөртөө нэгтгэсэн.

Экспортын тээврийн хувьд Каус Аустралис, транзит тээврийн хувьд Монложистикс Транзит, бусад тээврийн хувьд Монложистикс Тракинг, Монложистикс ОХУ дахь салбар охин компани болон Монложистикс Экүйпментс гэх хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн үйл ажиллагаа явуулдаг компаниудтайгаар группийн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

### **Тээврийн үзүүлэлтүүд**

2024 оны эхний хагаст Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон Монгол улсын тээвэр ложистикийн салбарын үзүүлэлтүүд маш эерэг гарсан. Монгол улсын тээврийн салбарын орлогын өсөлт өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 25%-иар өссөн. Нөгөө талдаа Монложистикс группийн борлуулалтын орлого 55%-иар, цэвэр ашиг 45%-иар өссөн. Ачааны тоо хэмжээгээр нийт группийн хэмжээнд 13%-иар өссөн, экспорт 21%-иар, монложистиксийн импорт нь 15%-иар, транзит ачаа 11%-иар буюу үндсэн бизнесийн чиглэлүүд бүгд жигд өсөлттэй хагас жил байлаа.

### **Группийн түүхэн замнал**

Группийн түүхэн замналын хувьд 2005 онд Монложистикс Ворлдвайд нэртэйгээр үүсгэн байгуулагдаж байсан. Үүнээс хойш манайх тасралтгүй өөрийгөө шинэчилж, сайжруулж нөгөө талдаа манай санхүү болон ачааны хэмжээ мөн тасралтгүй өссөн. Онцлох зүйл гэвэл 2015 онд бид нар ISO 9001:2008-г нэвтрүүлж байсан. 2017 онд салбартаа хамгийн анхны бүх тээврийг ачаа тээврийн даатгалд хамруулсан компани болж байсан. 2018 оноос ерөнхийдөө группийн бүтэц рүү орсон. Группийн бүтэц рүү орсны дараа маш олон охин компаниудыг бий болгосон байгаа.

### **Онцлох үйл явдлууд**

2024 оны онцлох зүйл нь Төв Азийн Замын 51%-ийг өөртөө нэгтгэсэн явдал байна. Энэ онд мөн Монложистикс Ворлдвайд компани Эрдэнэт үйлдвэрийн баяжуулах үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлийн төслийн ачаа босгох трансформатор тоног төхөөрөмжийг амжилттай тээвэрлэсэн. Эрдэнэт үйлдвэртэй шууд гэрээ байгуулаагүй. Харин Эрдэнэт үйлдвэрийн энэхүү тоног төхөөрөмжийг нийлүүлэгч байгууллагатай нь гэрээ байгуулаад тээврийг нь хийж гүйцэтгэсэн. мянганы сорилтын сангийн гэр хорооллын ус түгээх, байр автоматжуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж суурилуулах төслийн ачаануудыг сүүлийн 10 сарын хугацаанд амжилттай тээвэрлэж гүйцэтгэж дууссан.

Монложистикс Транзит буюу Монгол Улсаар дамжин өнгөрч байгаа төмөр замын тээврийн үйл ажиллагаа явуулдаг компани маань 5-р сард анх удаа транзит тээврээр тоног төхөөрөмж амжилттай тээвэрлэж тус тээвэр дээр 45 тн, 54 тн жинтэй тоног төхөөрөмжүүдийг тус тус ОХУ-ын Никель өртөө рүү тээвэрлэсэн байна. Монложистикс Тракинг шинэ үйлчилгээ нэвтрүүлсэн. Бид нар чингэлэг депо үйлчилгээ буюу чингэлгийн хадгаламжийн талбайг аль болох олон улсын чингэлэг эзэмшигч нарын шаардлагад

нийцсэн талбайг үйл ажиллагаандаа нэвтрүүлж тэдгээр байгууллагуудынхаа чингэлгийг энд хадгалж үзсэн.

Дараагийн нэг онцлох үйл явдал бол манай Монложистикс Карго компанийн явуулдаг Sheeran брэнд 120 мянга дахь хэрэглэгчээ бүртгэж авсан. Монложистикс Транс Сервис компани буюу манай ОХУ-ын салбар компани 2024 оны 5-р сард ОХУ-ын экспорт, импорт, дотоодын тээвэр, техникийн нислэг хийх зориулалттай хаалттай вагоны тоог амжилттай нэмэгдүүлж ажиллалаа. Мөн экспортын чингэлэг тээвэрлэлтийг Клешинг Улаанбаатар чиглэлд амжилттай зохион байгуулсан. Иймэрхүү онцлог тээврүүдийг бид нар хагас жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс гадна нэлээдгүй хэдэн онцлох үйл явдлууд болсон. Нэгдүгээрт, Монложистикс Холдинг компани өнгөрсөн жил IPO хийсэн, энэ жилээс бид нар хөрөнгө оруулагчдын харилцаагаа хөгжүүлэх үүднээс Investor Relations (IR) гэдэг функцийг мэргэжлийн түвшинд гаргах үүднээс мэргэжлийн зөвлөх үйлчилгээний CMM компанитай гэрээ байгуулсан. Энэ үйлчилгээ маань бүтэн жилийн хугацаанд бид нар CMM-с зөвлөгөө аваад өөрсдийнхөө хөрөнгө оруулагчдын харилцаагаа илүү бүтээмжтэй болгох, илүү нээлттэй болгох, илүү ил тод шилэн болгох тал дээр үргэлжлүүлж ажиллана. Мөн манайх өөрсдийн дотооддоо бий болгосон TMS гэдэг транспорт менежмент системээ шинэчлээд ложистик менежмент систем LMS-г болгож хувиргасан. Энэ нь бид ирээдүйд хэрэглэгч болон дотооддоо дижитал шилжилтийг эрчимтэй эрчимжүүлэх үүднээс суурь технологийн шинэчлэлийг амжилттайгаар нэвтрүүлсэн.

Гурав дахь онцлох үйл явдал нь манай вагоны худалдан авалт энэ жилээс хийгдэж эхэлсэн. Бид нар эхний захиалгаа хийгээд, захиалга маань бэлэн болоод эхний вагонууд маань наашаа хөдлөхөд бэлэн болсон байгаа гэдгийг дуулгахад таатай байна. Монложистикс Холдингийн зүгээс техникийн үзлэгийн баг очоод техникийн шаардлага шалгалтаа хийгээд хүлээн авах үйл ажиллагаа амжилттай болсон. Ойрын хугацаанд наашаа хөдлөөд бид нарын таамаглалаар 8 сардаа багтаад үйл ажиллагаа, тээвэрт яваад эхэлнэ. Вагон дээр мөн нэмэлт мэдээлэл та бүхэнд нэмж хэлэхэд бид нар эхний захиалга амжилттай болсон учраас 2 дахь захиалгынхаа ажлыг хийсэн байгаа. Хоёр дахь захиалга 40 ширхэг вагоноос бүрдэж байгаа бөгөөд энэ жилийн эцэст нийт 50 вагоны паркттай болсон байна гэж төлөвлөж байна.

Өнгөрсөн 6-р сард БНХАУ-ын Тяньжин хотод Транспорт Ложистик гээд Экспо болдог. Манай салбарын дэлхийн хамгийн том экспоны үеэр Монложистикс групп нь Хятадын төрийн өмчит "China State Railway" гэдэг компанийн охин компани болох чингэлэг тээврийн компани China Railway International Multimodal Transport Co.Ltd гэдэг компанитай олон талт стратегийн хамтын ажиллагааны гэрээг байгуулсан нь бид нарын өнгөрсөн 2-оос 3 жилийн хугацаанд хөөцөлдсөн ажил маань бодитой хэрэгжилт болсон. Энэ гэрээний хүрээнд бид нар Монголын импорт экспорт болон Монголоор дамжин өнгөрч байгаа транзит дээр бүх бизнес дээр хамтран ажиллах үүд хаалга нээгдэж байгаа. Нөгөө талаас Монголын дэд бүтцэд хөрөнгө оруулалтын ажлуудыг хамтарч хийх төслүүд үүний хүрээнд яригдаж байна. Транспорт Ложистик 2024 арга хэмжээнд Монложистикс группээс нэлээн өргөн

бүрэлдэхүүнтэй буюу группийн 4 охин компанийн төлөөлөл 15 орчим хүний бүрэлдэхүүнтэйгээр экспод амжилттай оролцсон.

Мэдээж хувьцаа эзэмшигчдийнхээ анхны ээлжит хурлыг бид нар 4 сарын 27-ны өдөр амжилттай хийж гүйцэтгэсэн. Төв Азийн Зам гэдэг компанийн 51%-ийг Монложистикс групп нь өөрсдөө нэгтгэсэн бөгөөд Төв Азийн зам нь Тэсо Инвентментийн хөрөнгө оруулалттай суудлын автомашины импортын тээвэр ложистикийн үйл ажиллагаа явуулдаг. Суудлын автомашины зах зээл дээрээ нэлээдгүй том байр суурийг эзэлдэг топ компаниудынх нь нэг. Улсын хэмжээнд нийт импортын 20%-ийг бүрдүүлдэг суудлын автомашины импортын сегмент рүү ингээд богино хугацаанд нэвтэрч байна. Төв Азийн Зам нь Тэсогийн 80%-ийн эзэмшилтэй компани байсан. Хэлэлцээрийн дараа Тэсо Инвентмент 39.1%, Мөнхжаргал гээд одоогийн гүйцэтгэх захирал нь 9.8%, Монложистикс Холдинг 51.1%-ийг эзэмшиж байна.

Эндээс хэдэн зүйлийг онцолж хэлэхэд нэгдүгээрт Монложистикс групп Тэсод орсноороо Тэсогийн тээвэр ложистикийн үйл ажиллагааг нэлээдгүй сайжруулах потенциалтай гэж харж байгаа. Бид нарын хувьд агент сонголт, Японоос суудлын автомашины тээврийн зохион байгуулалт Ёкохама пост дээрх үйл ажиллагаанаас эхлээд далайн тээврийн компанийн сонголт, Тяньжин дээрх үйл ажиллагаа, наашаа ачуулах зэрэг бүх талд нь бид нар сайжруулалт хийх гээд ажлууд хоёр талаасаа эхэлсэн явж байна. Нөгөө талдаа бид нарын харж байгаагаар М&А хэд хэдэн давуу талуудтай байдаг. Үүний хамгийн том давуу тал нь хүний нөөцийн асуудлыг шийддэг. Монгол улс хүний нөөцийн хомсдолтой, хүний нөөцийн жижиг хямралд бид бүхэн орсон яваад байгаа үед бизнесийн тэлэлтийг М&А-р хийснээр туршлагатай хамт олныг шууд өөртөө нэгтгэж байгаагаараа том давуу талтай. Тэсо групп дээр бид нар бизнесийн хамтрагчид болж байгаагаараа цаашид Тэсо групптэй илүү ойр дотно ажиллах, менежментийн ноу хау солилцох, яг бизнес хамтрал хийх боломжтой болж байгаа гэж харж байна. Өнгөрсөн 2023 оны 11 сараас хойш бид нар яриа хэлэлцээр хийсний үр дүнд 6 сард хэлэлцээрээ хийсэн. ТУЗ-ийн хороогоор хүлээн авч энэхүү хэлэлцээр амжилттай болсон. Хэлэлцээрийн онцлох зүйл нь Төв Азийн Замаас цэвэр ашгийн баталгаа ирэх 3 жилийн хугацаанд авсан бөгөөд баталгаат дүнтэй харьцуулж үнэлгээ нь хувьсах үнэлгээний механизмаар одоогийн хувьцаа эзэмшигчидтэй нь тохиролцсон. Бид нар ямар санхүү, тоо үзүүлэлтээр, ямар үр дүнг хүлээж байгаа вэ гэвэл борлуулалтын орлого 19%-иар өснө гэж харж байгаа, манай нийт ажилчдын тоо 22%-аар өссөн байна. Импортын тээврийн хэмжээ 13%-аар, цэвэр ашиг 10%-иас 15% өсөх хүлээлттэй байна. Цаашид энэхүү синержинүүд нь ажиллаад бүр илүү өндөр өсөлт хийх потенциал байгаа гэж харж байна. Суудлын автомашины зах зээлд энэ жилийн хувьд олон наадам 100 жилүүд байгаа мөн иений ханш суларсантай холбоотой өмнөх жилтэй харьцуулахад нийт Монгол улс руу чиглэж байгаа суудлын автомашины импорт 100% буюу нугарсан маш төсөвтэй жил байна.

### **Стратеги болон санхүүгийн зорилго**

Алсын хараандаа хүрэхэд бид нар 2024 онд хэд хэдэн ажлуудыг төлөвлөсөн байсан. Нэгдүгээрт экспорт тээврийн өргөжилтийг үргэлжлүүлэх, үүнийг бид нар өөрсдийн худалдан авч байгаа вагоноороо энэхүү өсөлтийг бий болгоно. Нөгөө талдаа богино дунд

хугацаанд өсөлт бий болгох M&A боломжийг судалж, энэний хүрээнд Төв Азийн Замын хэлэлцээр амжилттай болсон. Үүний хажуугаар дэд бүтцийн төслүүдийг эхлүүлэхээр ажиллаж байна. Вагон депо, тэнхлэг депо үйлчилгээ нь дэд бүтцийн төслүүдийн эхлэлд бий болсон. Цаашид ч бид нар олон дэд бүтцийн судалгаанууд үүний хажуугаар давхар холдинг дээр хийгээд явж байна. Мөн ISO 9001:2015 гэсэн чанарын удирдлагын тогтолцоог группийн хэмжээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. 2025, 2027 онуудад хөдлөх бүрэлдэхүүний баазыг нэмэгдүүлэх, гадаад борлуулалтын сувгаа өргөжүүлэх, хүнд дэд бүтцэдээ ажил хэрэг болгох, олон улс дахь салбарын тоо хэмжээг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийнэ. 2027 оноос олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх ажил байгаа. Үүний бэлтгэл ажлыг нь энэ жилээс ярьж эхэлж байна. Хамгийн түрүүнд бид нар энэ жилд өөрсдийнхөө санхүүгийн гаднын аудитораа BIG 4 болгохоор төлөвлөж ярьж байна.

## **Бизнес модель**

Манай компанийн нийт хөрөнгө оруулагчдад хамгийн том ойлгуулахад хэцүү байдаг зүйл бол манай бизнес модель. Бид нар өнөөдрийн байдлаар мэргэжлийн хэллэгээр third party logistics буюу 3PL үйлчилгээг нийт Монголын импорт экспортын зах зээлийн харилцагчдадаа санал болгож байна. Энэ бол илүү тээврийн мэргэжлийн байгууллагаар үйлчлүүлэх гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл худалдааны байгууллагууд өөрсдөө тээврээ хийх биш харин тэрийг нь зуучилж өгдөг тодорхой үнэ цэнийг бий болгодог тээврийн мэргэжлийн байгууллагаас цогц үйлчилгээг аваад явах энэхүү үйлчилгээг 3PL гэж нэрлэдэг. Манайхан илүү тээвэр зууч гэж нэрлэдэг бөгөөд Фред форвардын үйлчилгээг илүү санал болгож байна. Гэхдээ түрүүний хэлсэн өөрсдийн машин хөдлөх бүрэлдэхүүн, өөрсдийн вагон орж ирснээрээ бид нар фред форвардын зууч хэлбэрээсээ илүү карьер буюу тээвэрлэгч хэлбэр лүүгээ шилжиж байгаагийн нэг хэлбэр. Шилжилт нэлээн удаан хугацаанд үргэлжилнэ. Гэхдээ цаашдын манай стратегийн маш том чухал хэсэг яах аргагүй мөн гэж харж байна.

## **2024 оны зорилт**

2024 оны санхүүгийн төлөвлөгөө бол жилийн эцсийн хувьд нийт ₮13-аас ₮15 тэрбумын цэвэр ашигтай ажиллана гэдэг төсөөлөлтэй байна. Хагас жилийн байдлаар яг төлөвлөгөөнийхөө дагуу явж байна. Цэвэр ашиг 5%-иас 5.1% байна. Өмнө жилтэй харьцуулбал 50%-иас 60%-ийн цэвэр ашгийн өсөлт харуулна гэж зорьж ажиллаж байна. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын хувьд бид нар нийт зах зээлээс өнгөрсөн жилийн 9-р сард IPO-н үйл ажиллагааны хүрээнд ₮10.9 тэрбумыг татан төвлөрүүлсэн. Үүний ₮8 тэрбум хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт, ₮2.9 тэрбум нь эргэлтийн хөрөнгө зарцуулна гэдэг төлөвлөгөөтэй байсан. Өнөөдрийн байдлаар бид нар хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалтад ₮398 саяыг зарцуулсан нь эхний 10 вагоны захиалга байгаа. Энэхүү компани дээр дараагийн 40 вагоноо захиалах гээд ярьж байна. Иргэдийн хөрөнгийн зохицуулалт үндсэндээ бүрэн хийгдсэн. Бид нар ₮2.8 тэрбумыг өөрсдийнхөө охин компаниудыг санхүүжүүлэхэд хөрөнгө оруулсан байна. Нөгөө талд нь Төв Азийн Замын хэлэлцээр дээр ₮3.5 тэрбумын хөрөнгө оруулалт хийсэн. Нийт дүнгээр нь харвал ₮6.7 тэрбумын хөрөнгө оруулалтыг хийсэн, үлдэгдэл ₮4.2 тэрбум байна. Энэхүү үлдэгдлээ

бид нар үлдсэн вагоны захиалга болон бусад жижиг төслүүд дээр зарцуулаад энэ жилдээ татан төвлөрүүлсэн хөрөнгөө бүрэн зарцуулна харж байна.

**Үйл ажиллагааны тайланг Санхүү эрхэлсэн захирал 3.Шинэ-Од та бүхэнд танилцуулна.**

**3.Шинэ-Од (Монложистикс Холдинг ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал):** Сайн байцгаана уу? Монложистикс группийн үйл ажиллагааны тайланг цааш нь үргэлжлүүлээд явъя. Бид үйл ажиллагаагаа сегмент бүрээр, улирал болгон танилцуулаад явж байгаа бөгөөд үзүүлэлтүүдээ салбарын орлоготой хамт үзүүлээд явж байгаа. Бид үйл ажиллагаагаа сегмент бүрээр, улирал болгон танилцуулаад явж байгаа бөгөөд үзүүлэлтүүдээ салбарын орлоготой хамт үзүүлээд явж байгаа. Тээврийн салбарын орлого 25%-иар өссөн. Оны эхэнд тээврийн салбарыг 20 орчим өснө гэсэн өөрсдийн таамаглалтай ажиллаж байсан ч хүлээлтээс өндөр гарсан. Экспортын тээвэр хүлээлтээс нэлээн өндөр өсөлттэй байгаа зэрэг нь энд нөлөө үзүүлж байна. Монложистикс группийн хувьд борлуулалтын орлого 55%-иар өссөн. 2023 оноос 55%-иар өссөнд хэд хэдэн хүчин зүйл байгаа. Нэгдүгээрт нь мэдээж сегмент бүрийн ачааны хэмжээ өсөж байгаа, нөгөө талд тээвэр ложистикийн зах зээлд үүсэж байгаа нөхцөл байдлаас хамаараад тээврийн дундаж үнэ өсөж байгаа.

Дараа нь ОХУ-ын нөхцөл байдал, 2-т нь Европоос Монгол улс руу ирэх ачаа тээвэр Улаан тэнгист болсон асуудлаас болоод нэмэлт өртгүүд шаардаж байгаа, Африк тивийг тойрч зам уртсаж байгаа, мөн Тяньжин боомтын асуудал хүн бүрд мэдэгдээд эхэлсэн. Эдгээр нөлөө нь тээврийн хугацаа сунгаж байгаа сөрөг нөлөө ихтэй боловч нэгж үнийг өсгөж байгаа нь Монложистикс группийн орлогыг нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн.

Ачаа тээврийн өсөлт Монгол улсын хэмжээнд 27.1% байгаа нь бид нарын хүлээлтээс өндөр яваад байна. Монложистикс группийн ачаа тээврийн хэмжээ 12.8% өссөн байна. Нийтдээ 570 мянган тн ачаа тээвэр тээвэрлэсэн байна. Экспортын ачаа тээврийн хэмжээ Монгол улсын хэмжээнд 36.2%-иар өсөж 46 сая тн-д хүрсэн. Монложистикс группийн хэмжээнд 21%-иар өссөн, бид нар экспортын зах зээлд маш шинэ тоглогч байгаа. Бид нар 2022 оноос л үйл ажиллагаагаа явуулаад амжилттай өсөлттэй явж байгаа. Бид нар дээр цаашдын өсөлтүүдээ экспорт дээр нэлээн төвлөрүүлчихсэн. Вагоны хөрөнгө оруулалт ийшээ чиглэсэн хөрөнгө оруулалт байгаа. Импортын ачаа тээврийн хэмжээ Монгол улсын хэмжээнд бага зэрэг бууралттай байна. Харин Монложистикс группийн хэмжээнд 14.5%-иар өсөж 51 мянган тн-д хүрсэн байна. Энэхүү нөлөөнд бид нарын худалдаж авсан Төв Азийн Зам компанийн хэмжээ ороод явсан гэж хэлмээр байна.

Транзит ачаа тээврийн хэмжээний хувьд Монгол Улсын хэмжээнд 9%-иар өссөн байна. Монложистикс группийн хувьд 11.3%-иар өсөж 400 мянган тн-д хүрсэн. Транзит тээврийн сегментэд нэлээн сорилтуудтай тулгарч байгаа. Юу болсон бэ гэхээр дэлхий нийтийн ОХУ-ын эсрэг авч байгаа хориг хэмжээ нь эхний хагас жилд 2 удаа чангарсан. 2 сард болон 6 сард гээд тодорхой тооны хүн албан байгууллагуудыг хоригт оруулах, түүний дараа төлбөр тооцооны асуудал улам чангарах гээд нэлээн нөхцөл байдлууд ярвигтай байгаа. Өөрөөр хэлбэл 2 улсын хооронд явж байгаа ачаа тээврийн урсгалд тодорхой



хэмжээнд нөлөө үзүүлж байна. Нөгөө талд төлбөр тооцооны асуудлыг үүсгэж байна. Эдгээр нөлөө нь юу болж байна вэ гэхээр манай олон улс дахь ачаа тээврийн хэмжээнд нөлөө үзүүлж байна. Өөрөөр хэлбэл Монложистикс группийн охин компани болох Транс Сервис компани маань ОХУ-д байршиж Хятад улсын хооронд, ОХУ дотроо тээвэрлэлтийг зохион байгуулдаг. Энэхүү тээвэрлэлтийн нөлөө нь төлбөр тооцооны асуудал Хятад компаниудын харилцагчид маань ОХУ руу ачаа явуулахад ачаа тээврийг хэрхэн явуулах вэ гээд шинэ сорилтуудтай тулгарчихсан явж байгаа.

### **Тогтвортой хөгжил**

Хамгийн эхний дурдах зүйл бол бид нар бүх ажилчдын хурлаа нэлээн өргөн цар хүрээнд өндөр ач холбогдолтой хийдэг. Энэ удаагийн хурал ямар зорилготойгоор болсон бэ гэвэл Монложистикс групп ХК буюу нээлттэй компани болоод дараагийн хурдтай өсөлтийг зорьж байгаа. Энэ өсөлтүүдийн зорилгын хүрээнд бүтээмжийг нэмэгдүүлэх ERP системийг бүрэн шинэчилж байна. ERP систем, тээврийн менежментийн систем болон ISO гээд компанийн дотор нэлээн ноцтой хөгжил рүү чиглэсэн олон арга хэмжээнүүд зэрэг болж байгаа учраас бүх группийн ажилчид нэг ойлголттой болох, зэрэг хамт нэг ойлголттойгоор бүгдийг биелүүлэх, дотроо нутагшуулах ажлыг нэлээн зорилго болгосон. Үүний хүрээнд бид нар "Хамтдаа хөтөлбөр" арга хэмжээг зохион байгуулсан. Энэ нь 7 хоногийн арга хэмжээ байсан бөгөөд яг ажилчид руу чиглэсэн тухай бүрчлэн арга хэмжээнүүд хийсэн.

Менежмент форум нь нэлээн чухал ажил болдог. нь ТУЗ-өөс зохион байгуулдаг удирдлага руу чиглэсэн стратеги, дараагийн бид нарын харах өнцөг хаана байна вэ гэдэг рүү чиглэсэн гаднын сургалт болон дотоод хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн томоохон форум болдог. Үүнээс гадна Future CEO 2 дахь хөтөлбөрүүд дээр зарласан. Үүн дээр бид нар дараагийн хөгжих боломжтой, манлайлах чадвартай залуучуудыг олж, тусалж дэмжих сургалтын төлбөрийг нь даах, амьдрах орчныг нь даах гээд нэг хүн дээр ₮40 сая гээд ₮120 саяын хөтөлбөр зохион байгуулж байсан. Үүний 2 дахь хөтөлбөр энэ жил дахин зарлагдаад сонгон шалгаруулалт нь явж байна.

KESO хөтөлбөр буюу тодорхой гол ажилчдад компанийн хувьцааг санал болгох хөтөлбөрийг санаачлаад тухайн ажилчидтай гэрээгээ байгуулсан. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь Монложистикс группийн нийт хувьцаа эзэмшигчидтэй адилхан удирдах баг маань адилхан ашиг сонирхолтой, зорилготой, нэг зүг рүү харахын тулд томоохон бүтээмжийг нэмэгдүүлсэн зөв чиглэлтэй, харах өнцгийг өгсөн том арга хэмжээ болсон гэж харж байна. Үүнээс тодорхой нэг арга хэмжээ дурдвал Санхүүгийн Монгол Улсын 10-р олимпиадыг нь алтан спонсороор бид нар ивээн тэтгэсэн. Энэ бол залуучуудад чухал дэмжлэг зорилго өгсөн үйл ажиллагаа болсон гэж итгэж байна.

### **Засаглал**

Засаглалын хувьд товчхон дурдъя. Засаглалын хувьд бид нар анхны ээлжит хурлаа онлайн хэлбэрээр зохион байгуулсан. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй байгаа. Хэрхэн ТУЗ маань хуралдсан бэ гэхээр нийт 4 удаагийн хурал болсон. Хороодын хурал нийтдээ 9 удаа хуралдаж нэлээн завгүй маш олон асуудлыг, том том хэлэлцээрүүд дээр

шийдвэр гаргасан хурлууд болсон байгаа. Өмнө нь хэлсэнчлэн бид нар хөрөнгө оруулагчтай харилцах харилцааг дараагийн шатанд гаргах илүү нээлттэй, ил тод зөв өнцгөөс харилцах үүднээс тодорхой хөтөлбөр гаргаад СММ-тэй хамтын ажиллагаа эхлүүлж, зөвлөх үйлчилгээг аваад явж байна. Үүнийг ТУЗ засаглалын хэмжээнд нэлээн томоохон чухалчилж үзээд хөтөлбөр батлуулсан байгаа. Технологи эрхэлсэн захирал маань шинээр бидний бүрэлдэхүүнд орж ирсэн маань бид нар группийн бодлого IT руу чиглэсэн, ирээдүйн бүтээмж хөгжил рүү чиглэсэн томоохон алхмууд хийж байгаа учраас багт нэмэгдсэн байгаа.

2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ноогдол ашиг ₮3 тэрбумыг 4 сарын 30-нд хуваарилсан. Нэгж хувьцаанд ₮7.58 байсан. Хувьцааны мэдээллийн хувьд бид нар Top 20 индексэд багтсан. Нийт Монложистикс холдинг компанийн хувьцаа маань ₮2.6 тэрбум орчим арилжаа хийгдсэн, өдрийн дундаж гүйлгээ ₮20 сая байсан.

Санхүүгийн тайлан дээр тодорхой дурдах зүйл маань 2024 оны 1 сарын 1-ээс Төв Азийн Замын компанийн тайлан нэгтгэгдсэн. Бид нарын худалдан авах гэрээ маань 2024 оны 1 сарын 1-ээр тогтоосон учраас бид нар тайландаа оруулсан байгаа. Манай орлого ₮141 тэрбумын болсон маань өнгөрсөн жилээс 45% өссөн. Эдгээрт Төв Азийн Зам нөлөө үзүүлсэн байгаа шүү гэдгийг дурдах нь зөв байх. Тэгэхээр бид нарын 2023 оноос өсөлт үзүүлсэн зардлын хэмжээн дээр ч гэсэн бүтэн нэг компанийн хэмжээнд зардлууд орж ирээд тоонуудыг өөрчилсөн нь харагдаж байна. Цэвэр ашгийн түвшин ₮6.6 тэрбумаар ажилласан, үүний толгой компани хувьцаа эзэмшигчдэд ₮4.9 тэрбум ногдож байгаа, хяналтын эрхгүй хугацаанд ₮1.6 тэрбум байгаа.

Санхүү байдлын тайлан дээр хэд хэдэн үзүүлэлтийг дурдах нь зөв байх. Нэгдүгээрт, ложистикийн салбар нь улирлын циклтэй нь 5 болон 9 сард нэлээн их тээвэр хүлээж авдаг. Үүнтэй холбоотой тухайн циклүүдэд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх ажлын капиталд томоохон өөрчлөлтүүд бий болдог. Тяньжин боомт дээр нэлээн өндөр ачаалал үүссэнээс болоод тээврийн хугацаа нэлээн уртсаж эхэлсэн. 80-аас дээш хоног Тяньжин боомтод 60 хоног хүлээх зэрэг нэлээн өндөр хугацаанууд шаардаж байгаа учраас авлагын болон өглөгийн эргэцэд тодорхой нөлөөнүүд үзүүлж байгаа. Мөн түүнчлэн Төв Азийн Зам гэдэг компани баланст нэгдсэнээр томоохон өөрчлөлтүүд авчирсан. Энэ нь өр зээл болон авлага гэсэн зүйлүүд дээр өөрчлөлт авчирч байгаа. Төв Азийн Зам компанийн томоохон борлуулалтынх нь хэсэг бол суудлын автомашины импортын тээвэр байдаг. Энэхүү тээвэр нь Транс Лийз гэсэн өөрсдийн аппликэйшнээр дамжуулан шууд захиалах, Монголд авчраад хүлээлгэж өгөх урт циклд авлага үүсгэх, төлбөр тооцоог нь урьдчилж хийх нөхцөл байдлууд үүсдэг учраас дансны авлагын хэмжээ болон урьдчилж орсон орлогын хэмжээн дээр тодорхой дүнгүүд нэмэгдчихсэн байгаа. Нөгөө талд транзитын сегмент дээр орлогын нэмэгдэл, ачаа тээврийн нэмэгдэл, урьдчилж төлсөн төлбөрийг өндөр дүнгээр нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн санхүүгийн тайлан байна. Нөгөө талаар харьцуулж байгаа тайлан маань 2023 оны эхний хагастай харьцуулж байгаа учраас хэд хэдэн том нөлөө байгааг дурдах нь зөв байх. Бид 2023 оны 9 сард нээлттэй компани болж олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн. Эздийн өмчийн хэсэгт томоохон өөрчлөлт үүссэн байгаа нь олон нийтээс татан төвлөрүүлсэн ₮10.9 тэрбумын дүн орсон байгаа учраас гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Ингээд товчхон тайланг танилцуулаад дуусгая. Та бүхэнд асуултууд байвал асууж болно.

**Г.Хишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** Энэ дээр хальт дүгнэлт хэлэхэд та бүхний харж байгаачлан 2024 оны эхний хагаст манай хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ, бүх түвшиндээ өндөр ачаалалтай ажиллацгаасан. Энэ нь бидний хийсэн ажлууд эхнээсээ ажил хэрэг болоод тоон үзүүлэлтүүд дээр харагдаж эхэлсэн байгаа. Бид нар жилийн өсөлт болон тогтвортой хөгжил гэсэн 2 үндсэн зорилтын хүрээнд эхлүүлсэн бөгөөд энэ нь үргэлжилж байгаа. Өсөлтийн хувьд бид нар цэвэр ашгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ачаа тээврийн өсөлтийг нэмэгдүүлэх тал дээр нэлээн олон төслүүдийг зэрэг ярьж байгаа нь эхнээсээ үр дүнгээ үзүүлээд эхэлжээ. Цаашид ч гэсэн үлдсэн төслүүд дээрээ төвлөрөөд явна. Тогтвортой хөгжлийн хувьд дотоод боловсон хүчнээ хөгжүүлэхээс гадна дижитал систем, суурь технологиудын шинэчлэл, дотоодын ISO хөтөлбөр зэрэг томоохон төслүүд зэрэг явагдаж байна. Энэ нь ч гэсэн цаашид үргэлжлээд явна. За баярлалаа.

**Б.Намхайдорж (Operator):** Хишигбат болон Шинэ-Од захиралдаа баярлалаа. Одоогоор асуулт орж ирээгүй байгаа болохоор Earnings call-н өмнө ирсэн асуултуудаас асууж байна. Эхний асуулт бол үнэт цаасны танилцуулга дээр ашгийн тодорхой хувийг ханшийн зөрүүний олз бүрдүүлэхээр төлөвлөж байсан. Одоогийн байдлаар ам.долларын ханш бууралттай байгаа нь цаашид ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлөхөөр байгаа вэ?

**Г.Хишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** Манай нийт орлогын 80% орчим нь гадаад валютаар тооцогддог бөгөөд тэр дундаа дийлэнх нь ам доллароор орлого бүртгэгддэг байгаа. Тийм учраас бид өнгөрсөн хугацаанд төгрөг суларсан жилүүдэд ханшийн зөрүүний олзыг тухайн төгрөг хэдий хэмжээгээр суларснаас хамаараад олз орж ирдэг байсан. Энэ жилийн хувьд бид төгрөгийг тодорхой хэмжээнд суларна гэж харж байсан учраас олз бүртгэсэн. Гэхдээ нөгөө талд төгрөг нь бусад валютуудтай харьцуулахад нэлээн тогтвортой байгаа учраас энэ олз орж ирээгүй байгаа. Цаашид бидний харж байгаагаар 2024 оны 2 дугаар хагаст төгрөг бага зэрэг сулрах болов уу гэдэг хүлээлт байгаа. Эндээс бага зэргийн ашгийн зөрүүний олз орж ирнэ гэж харж байгаа.

**Б.Намхайдорж (Operator):** Баярлалаа. Дараагийн асуулт бол борлуулалтын орлогын өсөлт нь тээвэр ложистикийн тээвэрлэсэн ачааны өсөлттэй шууд хамааралтай харагдаж байна. Макро хүчин зүйлээс үүдэлтэй тээвэрлэлтийн ачаа буурсан тохиолдолд борлуулалтын орлогод хэрхэн нөлөөлдөг вэ? Тэр эрсдэлийг нь яаж хүрэх хэмжээнд нь нэмж хийдэг вэ? гэж асуусан байна.

**Г.Хишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** Манай тээврийн салбарын нэг онцлог бол бид өөрсдийгөө нийт макро эдийн засгийн тэргүүлэгч индикатор (leading indicator) буюу өмнө нь явж байдаг үзүүлэлт гэж хардаг. Тээврийн салбар өсөх юм бол дагаад макро эдийн засаг нь тэрэнтэй холбоотойгоор өсдөг. Өнгөрсөн эхний хагасын хувьд манай 1-р улирал дээр ДНБ 7% гаруй өссөн. Үүнийг дагаад төлбөрийн тэнцэл болон төсөв эерэг гарсан. Импортоос бусад бүх л салбарууд ачаа тээврийн хэмжээгээр өссөн. Үнийн дүнгээр харьцуулбал бүх сегментүүд өссөн байгаа. Энэ нь мэдээж компани хөгжихөд маш сайн түлхэц болж өгнө. Гэхдээ нөгөө талдаа эдийн засгийн өсөлт саармагжаад ирэхээр юу болдог вэ гэхээр хэдийгээр бид тээврийн салбар дотроо үйл ажиллагаа явуулж байгаа ч гэсэн тээврийн салбарын сегментүүд хоорондоо харилцан

уялдаагүй байдаг. Тийм учраас Монголын эдийн засгийн өсөлт саармагжих үед транзитын өсөлт нь нөхдөг ч юм уу эсвэл Монголын экспорт нь буурах үед импорт нь өсдөг ч юм уу иймэрхүү хоорондын харилцан уялдаа бага байдаг. Иймд илүү төрөлжсөн, солонгорсон орлогын эх үүсвэртэй байгаа учраас манай борлуулалтын орлого өнгөрсөн 19 жилийн түүхэнд 2 жил л буурсан үзүүлэлттэй байдаг. Нөгөө талаас мэдээжийн хэрэг манай маш олон жил хамтарч ажиллаж байгаа харилцагчид байна. Тухайн харилцагчдын маань бизнес өргөжихийн хэрээр манай ачаанууд давхар өсөөд явдаг.

**Б.Намхайдорж (Operator):** Баярлалаа. Дараагийн асуулт нь борлуулалтын өртөг сүүлийн 3 жилд өссөн хандлагатай байна. Энэ нь цаашид хадгалагдах уу? Борлуулалтын өртгөө ямар хэмжээнд барихыг зорьдог вэ? гэсэн байна.

**Г.Жишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** Манай борлуулалтын өртөг гэхээр та бүхэн ойлгох хэрэгтэй. Манай ББӨ (борлуулсан бүтээгдэхүүний өртөг) цэвэр дийлэнх нь бол гадаад болон дотоод орон зайд хийгдэж байгаа тээврийн өртөг гэж харж болно. Энийг төлөвлөхөд нэг талаасаа нэлээн төвөгтэй байдаг. Учир нь гадаад хүчин зүйлийн нөлөөлөл маш хүчтэйгээр орж ирдэг. Энд харагдаж байгаа өссөн трендийн дийлэнх нь манай нийт ачааны эргэлдэж байгаа тоо хэмжээ өссөнтэй холбоотой. Нөгөө талаас Шинэ-Од захирлын дурдсанчлан том нөлөөнүүд бий. Жишээлбэл энэ жил импортын тээврийн хувьд хамгийн том нөлөө бол Тяньжин боомтын бөглөрөлтэй холбоотой үүсэж байна. Тяньжин боомт дээр нэг чингэлэг ойролцоогоор 60 орчим хоног царцаж байна. Тяньжинээс Эрээн рүү аялж байгаа төмөр замын план баг батлагдсантай холбоотой тэнд бөөгнөрөл үүссэн. Бөөгнөрөл үүссэнээр зарим ачаа тээврүүд авто руу шилждэг. Авто руу шилжсэн тохиолдолд нэгж чингэлэг дээр жишээлбэл \$700-с \$800 өртөг нэмэгддэг. Тэгэхээр иймэрхүү төлөвлөгдөөгүй нөлөө, нөгөө талдаа түрүүн хэлсэн ОХУ-ын төвөгтэй нөхцөл байдал, ОХУ-д тавигдсан хоригийн нөлөөтэй холбоотой Европоос ирж байгаа дийлэнх Монголын ачаанууд Тяньжин боомтоор ирдэг болсон гэдэгтэй холбоотойгоор мөн л тээврийн зардал өсөж байна. Мэдээжийн хэрэг нефтийн ханш чухал нөлөөтэй. Нефтийн ханш манай тээврийн зах зээлийн хамгийн том түүхий эд учраас нефтийн ханш ямар байгаагаас хамаараад борлуулсан бүтээгдэхүүний өртөг маань хэлбэлздэг байгаа. Манай борлуулалт яаж явдаг вэ гэхээр дийлэнх борлуулалт урт хугацаанд барих тарифтай гэхээсээ илүүтэйгээр бид нар тухай бүрчлэн ачааны өртгийг тооцоод, үүн дээрээ үндэслэж хэрэглэгчдэдээ үнийг тогтмол санал болгож явдаг. Өөрөөр хэлбэл 1-р сард бид нар ийм үнээр үйлчилгээгээ борлуулна гэдэг юм байдаггүй. Бид нар тухай бүрд нь тухайн нөхцөл байдлаасаа хамаараад тухайн ачаан дээр үнэ өртгийг тооцож явдаг байгаа.

**Б.Намхайдорж (Operator):** Баярлалаа. Сүүлийн 3 жилийн трендийг харвал борлуулалтын орлогын өсөлт нь 30% гаруй байгаад байгаа. Энэ тренд нь хэр удаан хадгалагдах вэ? Жишээлбэл өсөлтийн доод хэмжээ ч юм уу барьж байгаа стартегийн хувь хэмжээ нь юу байгаа гэж асуусан байна.

**Г.Жишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** Өнгөрсөн 3 жилийн хувьд манай групп үйл ажиллагааны хувьд маш их хэмжээгээр тэлсэн. Үүнтэй холбоотой борлуулалтын орлого тогтмол өсөөд явж байна. Мэдээжийн хэрэг цаашид бид нар өсөлт

үзүүлэх зорилтын хүрээнд өсгөөд явах гэж ажиллана гэхдээ нөгөө талд зөвхөн борлуулалтын орлогоо өсгөөд авдаггүй. Бид нар дотоод бүтээмж дээрээ нэлээн анхаарч байгаа өөрөөр хэлбэл нэгж ачаанаас авах цэвэр ашгийн хэмжээ, нийт ашгийн хэмжээг арай илүү тогтмол хэмжээнд барих гэж ажиллана. Үйл ажиллагааны удирдлагын зардлын дийлэнх хэсгийг хүмүүсийн цалин урамшууллын зардал эзэлдэг, нөгөө талаас дараагийн том зардал нь оффисын зардлууд ордог байгаа. Монгол улсын инфляцтай нийт боловсон хүчний зах зээл дээр үүссэн хомсдолтой холбоотойгоор цалингийн зардал бид нарын таамаглаж байснаас арай өндөр хэмжээгээр өсөөд байгаа. Цаашид бид нар ямар бодлого баримтлах вэ гэхээр дотоодын ажилчдадаа цалин урамшууллын хэмжээг нь зах зээлтэй нь уялдуулаад, өрсөлдөхүйц цалин урамшууллаар нь хангаад явна. Нөгөө талаас бид нар ирэх жилээс RPA гэж нэрлээд байгаа, үйл ажиллагаандаа нэлээн их робот автоматжуулалтыг нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа. Ингэснээр бид нар одоогийн бүтэц бүрэлдэхүүнээрээ илүү бүтээмжээ нэмэгдүүлэх боломжтой гэж харж байгаа. Тэгэхээр орлогын өсөлтөө бид нар цаашид ингээд хадгалаад явах тал дээр ажиллана. Бүтээмжээ хадгалж үүнээсээ дээшлүүлж цэвэр ашиг болон хувьцаа эзэмшигч нарт өгөх үнэ цэнийг нэмэгдүүлэх тал дээр мөн давхар ажиллана.

**Б.Намхайдорж (Operator):** Сүүлийн асуулт нь богино болон дунд хугацааны стратеги дээр хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалтыг үл хөдлөхийн капитал хөрөнгө оруулалт нэлээн хийнэ гэж төлөвлөсөн байсан. Үүний санхүүжилтийн эх үүсвэрүүдийг ямар эх үүсвэрээр ингэж төлөвлөж байгаа вэ? Үүнтэй холбоотой ногдол ашгийг тогтвортой тогтмол тараах уу хуваарилах уу гэж асуусан байна.

**Г.Хишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** Цаашид бид нарын үнэт цаасны танилцуулга дээр харж байсанчлан бид нар дийлэнх өсөлтөө бол уул уурхайн түүхий эдийн экспортын тээвэр дээр хийнэ гэж төлөвлөж байгаа. Манайх уул уурхайн түүхий эдийн экспорт дээр одоогийн байдлаар жижиг тоглогч хэвээрээ байгаа. Бид нар өөрсдийнхөө хөдлөх бүрэлдэхүүн нөөцийг илүү нэмэгдүүлж байж арай өндөр хувь эзлэх боломжтой болно. Тэгэхээр бид нар энэ жилдээ ямар ч байсан 50 вагоныхоо бүрэлдэхүүнийг бүрдүүлнэ. Үүгээрээ бид нар ирэх жил ажлуудаа хийнэ. Ирэх жилийн өсөлтийг энэхүү вагоноос илүү харж болно. Ирэх жилийн хувьд ч гэсэн бид нар тасралтгүй тухайн зээлийнх нь нөхцөл байдлаас хамаараад вагоны зогсоолоо нэмэгдүүлээд явна гэсэн төлөвлөгөөтэйгөө ямар ч байсан хөрөнгө оруулагч нартаа амласан цөөн вагоноо бид нар бүрдүүлнэ. Цаашаа өөр өсөлтийн эх үүсвэрүүд гэвэл бид нар гаднын өсөлтийн эх үүсвэрийн сувгуудыг хөгжүүлнэ гэж харж байгаа. Тэрнийхээ хүрээнд 11 сараас Узбекистан улс руу нэлээн өргөн бүрэлдэхүүнтэйгээр зах зээлтэй танилцах нэг аяллыг зохион байгуулж байна. Хэд хэдэн тээврийн компанитай бид нар уулзана. Ногдол ашгийн хувьд гэх юм бол бид нар мөн л ялгаагүй ногдол ашиг тогтмол зарлаад явна. Гэхдээ хагас жилээр биш жилийн эцсийн үйл ажиллагааны тайлангаас хамаарч ногдол ашгийн шийдвэр гарна.

**Б.Намхайдорж (Operator):** Баярлалаа. Асуулт хариултын хэсэг маань ингээд дууслаа. Энэ удаагийн Earnings call үүгээр дуусаж байна. Оролцсон Монложистикийн Гүйцэтгэх захирал Хишигбат болон Санхүү эрхэлсэн захирал Шинэ-Од нарт баярлалаа.

**Г.Хишигбат (Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал):** Бид нарыг урьж оролцуулсанд баярлалаа. Сонирхож оролцож орж ирсэн бүх оролцогчдодоо мөн баярлалаа. Дараагийн earnings call-оор уулзацгаая. Баярлалаа.